



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид барилга бүртгэн авах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт тус дүүргийн төсвийн хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон, нийт 1,261,106,926.0 (нэг тэрбум хоёр зуун жаран нэгэн сая нэг зуун зургаан мянга есөн зуун хорин зургаа) төгрөгийн өртөг бүхий “Жижиг, дунд үйлдвэрлэл, инновацын хөгжлийг дэмжих төв”-ийн барилгыг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100803